

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН БИЕЧИЛСЭН ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

Б.Одбаатар. Удирдлагын академийн
Профессор, доктор (Ph.D)

Н.Мөнхбат. Удирдлагын академийн 8132 дугаар
дамжааны суралцагч, цагдаагийн хошууч

Хураангуй

Биечилсэн хамгаалалт нь гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй аюулгүй байдлын хамгаалалтын нэг хэлбэр юм. Энэхүү гүйцэтгэлд гэрч, хохирогчийн биечилсэн хамгаалалтын арга хэмжээнд тулгамдаж буй асуудал, эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээг санал болгосон.

Abstract

Personal protection is a form of security protection used to protect the lives and health of witnesses and victims from criminal attacks. This article proposes measures to improve the legal environment for witnesses and victims.

Төлхөөр өгс: Гэрч, хохирогч, биечилсэн хамгаалалт, аюулгүй байдал, эрх бэхий албан тушаалтан, заналхийлэгч.

Key words: Witness, victim, personal protection, safety, authorized officer, threatening.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19.1 дэх хэсэгт "... Төрөөс хэний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хэний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна...", 38.2.7 дахь хэсэгт "Засгийн газар ... дараах Үндсэн бэрэн эрхийг хэрэгжүүлнэ: хэний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх¹" гэж тус тус заасан байна. Уг хуулийн 10 дугаар зүйлийн "Хэний халдашгүй байх эрхийг хангах" тухай заалтаас харахад гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн яллагдагчийн эрх зүйн байдал,

¹ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1992 он. №1

шүүгдэгчийн халдашгүй байх эрх"-ийг хамгаалснаас биш хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэх гэрчийг хамгаалах асуудлыг орхигдуулсан байна.¹ Үндсэн хуулийн дээрх заалтууд нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөний нийтлэг байдлыг илэрхийлж байгаа төдийгүй тусгайлсан эрх бий болгоход чиглэгдсэн. Өөрөөр хэлбэл нийгмийн тодорхой харилцааны онцлогтой холбоотойгоор иргэний эдлэх эрхийн үндэс болох юм.

Тэгэхээр үндсэн хуулийн дээрх заалтуудаар Монгол Улсад гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг тусгайлан зохицуулах үндсэн хуулийн үндэслэл буй нь тодорхойлогдож байна.

Одоогоор гэмт хэргийг шалгаж, сэжигтэн, яллагдагчийн гэм бурууг тогтоох мөрдөн шалгах ажиллагааны арга тактик үндсэндээ “мэдээллийн арга”-д тулгуурлан хийгдэж байгаа нь тэдний гэм бурууг нотолж байгаа гол эх сурвалж гэрч, хохирогчийн мэдээлэл болж байна. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримтат мэдээлэл нь үндсэндээ гэрч, хохирогчийн мэдээлгээр тогтоогдох нөхцөл байдлыг бий болгож байна. Тиймээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад гэрч, хохирогч голлох үүрэг гүйцэтгэх оролцогч тул тэдний аюулгүй байдлыг хамгаалах асуудал чухал байр суурийг эзлэх болсон.

Үүнд үндэслэн гэрч, хохирогчийг хамгаалахыг нэр томъёоны хувьд тайлбарлан авч үзвэл.

Хууль зүйн ухааны докторантур Д.Энх-Амгалан: Гэрч, хохирогчийг хамгаалах гэдэг нь хэрэг явдлыг тодорхойлон батлахад холбогдох ямар нэгэн баримт гаргах этгээд, хохирсон этгээд зэргийг учирч болох элдэв аюул ослоос сэргийлэн, хөнөөл учруулахгүйн төлөө сахин харгалзахыг хэлнэ² гэсэн бол Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код: Гэрч, хохирогчийг хамгаалах гэдэг нь гэрч, хохирогч, төлөөний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд учирч болох аюулаас сэргийлэхийн тулд сахин хамгаалж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэлнэ³ гэсэн бол Бидний

¹ Оюунчимэг.Т. Гэрч. УБ., 2013 он. 116 дахь тал

² Энх-Амгалан,Д. (2013). Гэрч,хохирогчийг хамгаалах асуудал магистрантын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар. Билиг дээд сургууль

³ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. УБ., 2018 он. 511.2 дахь тал

бодлоор гэрч, хохирогчийг хамгаалах гэдэг нь бодит болон далд аюул занал, айдас, итгэлгүй байдал, бусад хязгаарлалтаас хамгаалах үйл ажиллагаа бөгөөд үргэн утгаараа эрхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах баталгааг хэлнэ гэж үзэж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах нь аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалт гэсэн 2 төрөлтэй. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь Урьдчилан сануулах, Тодорхой үйлдлийг хязгаарлах, Биечилсэн хамгаалалт, Мэдээллийн нууцлалыг хангах, Нэг бөрийн болон тусгай техник хэрэгсэлээр хангах, Аюулгүй газарт төр байрлуулах, Бичиг баримт солих, Нөхцөл шилжүүлэх, Гадаад төрхийг өөрчлөх зэрэг 9 төрөлтэй байдаг. Үүнээс биечилсэн хамгаалалт нь хөн, хөнч, санхүү, мөнгө шаардсан чухал хамгаалалтын хэлбэр юм.

Үүнээс биечилсэн хамгаалалт гэдэг нь гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй аюулгүй байдлын хамгаалалтын нэг хэлбэрийг хэлдэг.

Гэмт хэргийн бодит байдлыг шалгаж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг нотлоход багагүй хэмжээний саад учруулж байгаа асуудлын нэг нь гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг үр нөлөөлөх, заналхийлэх, тэдэнд шан харамж амлах замаар хуулийн хариуцлагаас мултрах гэсэн оролдлого нотлох ажиллагааны явцад төгөөмэл хэлбэрээр бий болж, хэргийн бодит үнэнийг гуйвуулах, яллагдагч этгээдэд ашигтайгаар шийдвэрлэх, төгөөний гэм бурууг хаацайлах сөрөг үр дагавараас хамгаалах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэглэдэг.

Сүүлийн 5 жилийн Биечилсэн хамгаалалтын арга хэмжээний тоон мэдээ:



Хүснэгт:2



Энэ нь цаашид хамгаалалтын тоон мэдээг хандлагатай байгаа бөгөөд практикт биечилсэн хамгаалалтад ажиллаж буй алба хаагчийн тоо хурдтай, ажлын ачаалалтай байдаг.

Биечилсэн хамгаалалтын журмын 4 дүгээр зүйлийн 4.6 дах

хэсэгт...нэг биечилсэн хамгаалалтад аюулын зэргийн төвшинд үндэслэн 3-5 алба хаагч өөрөг гүйцэтгэнэ¹ гэж заасан байдаг. Гэтэл хүн, хүнийн нөхц хэрэгжүүлж буй хамгаалалттай харьцуулахад бага

¹ <https://www.legalinfo.mn/annex/details/6569?lawid=10750> хандалт 2021.09.23

байдаг тул алба хаагчийн ажлын өндөр төвшинтэй бөгөөд багасгахын тулд журамд өндэслэн хэлтсийн орон тоог нэмэх шаардлага зүй ёсоор өссөж байна.

Төмнчлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд 7 дугаар зүйлийн 7.2 дах хэсэгт Шаардлагатай гэж эвэл энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ¹ гэж заасан боловч практикт хамгаалуулагч иргэнд нийгмийн туслалцаа эзлэхэд шаардагдах зардлыг төсвөөс шийдвэрлэдэггүй. Гүйцэтгэх ажлын зардлаас болон алба хаагчид хувиасаа гаргах тохиолдол элбэг байдаг.

Практикт гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бөхий этгээд, гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа эзэлсэн хэн, шаардлагатай тохиолдолд прокурор, шүүгчийг хамгаалалтад авч байгаа бөгөөд хэнд хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд оролцож буй шинжээч, орчуулагч, хэлмэрчийг биечилсэн хамгаалалтад авах шаардлага өссөж байна. Учир нь заналхийлэгч этгээдээс шинжээчид нөхцөл нөхцөл хуурамч дүгнэлт гаргуулах, орчуулагч, хэлмэрчид нөхцөл нөхцөл худал орчуулж, хэлмэрчлүүлэхээр хууль бус үйлдэл явуулж болзошгүй тул шаардлагатай тохиолдолд тэднийг хамгаалалтад авч болох талаар эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй.

2.1. Гадаад орны эрх зүйн зохицуулалтын талаар:

Монгол улс:

-Гэрч,

-Хохирогч,

-Хамаарал бөхий этгээд,

-Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бөхий мэдээлэл, баримт сэлт болон бусад байдлаар туслалцаа эзэлсэн хэн,

-Шаардлагатай тохиолдолд шүүгч, прокурор.

Турк улс:

-Турк улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд зааснаар хэнд хохирол, хор уршиг учруулсан гэмт хэргийг гэрчилсэн гэрч,

-10 жилээс дээш хугацаагаар хорих ялтай гэмт хэргийг гэрчилсэн гэрч,

-Зохион байгуулалттай гэмт бөлийн үйл ажиллагааг гэрчилсэн гэрч,

-Гэрчийн ойр дотно, төрөл, садны хэмжээ.

Оросын холбооны улс:

-Хохирогч,

-Гэрч,

- Хувийн мөрдөгч ,

-Шинжээч, орчуулагч, хэлмэрч

-Иргэний хариуцагч, иргэний нэхэмжлэгч, хохирогчийн төлөөлөгч болон хууль ёсны төлөөлөгч гэх мэт.

¹ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2014 он. №30

Энэхүү нээс эхлээд Оросын холбооны улс шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хамгаалалтад авдаг. Монгол улсын хувьд гадаад орны туршлагаас судлаж төрийн орны эрх зүйн онцлогт тохируулан нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж үзэж байна.

Дүгнэлт. Энэ бөгднээс нэгтгэн авч эхлээд төрийн хамгаалал, хяналт, үйлчилгээний гадна өлддэг байсан гэрч, хохирогчийг хамгаалан, тэдэнд төрийн хамгаалалтын найдвартай байдлыг ойлгуулан таниулж, улмаар хэргийн үнэн зөвийг тогтоох үйл явцад өөртөө итгэл нэмшилтэй оролцох боломжийг бүрдүүлж өгч байгаад гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох асуудлын гол ач холбогдол оршдог.

Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа эзлэх үндэсний хөтөлбөрт төрийн болон төрийн бус байгууллагаас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан тусгасан боловч хэрэгжилт хангалтгүй, төсөв, хөрөнгө суудаггүй, нэгдсэн удирдлагаар хангагдахгүй байгаад дүгнэлт хийж, гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээд, мэдээлэл өгсөн иргэнийг хамгаалах, тэдэнд нийгмийн үйлчилгээ эзлэх нэгдмэл системийг бий болгох нэгдсэн удирдлагаар хангах, насанд хүрээгүй хүүнийг хамгаалах, тэдгээртэй харилцах журам, стандарт байхгүй юм.

Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох гол ач холбогдол нь төрийн хамгаалал, үйлчилгээний гадна өлддэг байсан гэрч, хохирогчийг хамгаалах, хэргийн бодит үнэнийг тогтоох үйл явцад өөртөө итгэл нэмшилтэй оролцох боломжийг бүрдүүлэхийн тулд холбогдох хуулийг олон нийтэд сурталчилан таниулах ажлыг оновчтой, хөртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах, шүүх эрх мэдэл, хууль сахиулах болон төрийн, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн тусламж дэмжлэгийг авах, хоорондын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай гэдэг нь гадаадын зарим улс, орны энэ төрлийн харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалт, төрийн бодлого, шийдвэр тусгайлан боловсруулсан хөтөлбөр, төлөний хэрэгжилт зэргээс харагдаж байна.

Санал:

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр: Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн болон төрийн бус, нутгийн өөрөө удирдах байгууллагын өөрэг, оролцоог татаж оролцуулах хэрэгцээ шаардлагад үндэслэн

гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг уялдуулан зохицуулах чиг үүрэг бөхий улсын хэмжээний Зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэд байгуулах нь зүйтэй байна. Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдаж, бэрэлдэхүүнд нь санхүүгийн, хөдөлмөр, нийгэм хамгааллын болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэг бөхий байгууллага, прокурор, шүүх, холбогдох бусад байгууллагын төлөөлөл ажиллах ба Зөвлөлийн бэрэлдэхүүн ажиллах журмыг Засгийн газар баталж байхаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байхаар эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Насанд хэрэггүй гэрч, хохирогчид зөвлөх олон нийтэд төшиглэсэн хамгаалах үйлчилгээ, аюулгүй байдалд тавих нийтлэг шаардлага, аюулгүй байдлын орчныг тодорхойлох, үйлчилгээний чанарыг тодорхойлсон “Насанд хэрэггүй гэрч, хохирогчийг хамгаалах стандарт”-ыг боловсруулан батлуулах.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт..шаардлагатай тохиолдолд шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хамгаалалтад авна гэж шинээр хуульчилж үгэх. Учир нь заналхийлэгч этгээдээс шинжээчид нөлөөлөн хуурамч дүгнэлт гаргуулах, орчуулагч, хэлмэрчид нөлөөлөн худал орчуулж, хэлмэрчлүүлэхээр хууль бус үйлдэл явуулж болзошгүй тул шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хамгаалалтад авсанаар хэргийг нотлоход чухал ач холбогдолтой.

Бүтэц, зохион байгуулалтын талаар. Цагдаагийн байгууллагын гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж буй нэгжийг үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бие даасан төсөв, санхүүтэй болох асуудлыг шийдвэрлүүлэх, алба хаагчдын тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх;

Орон нутагт гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны удирдлага, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бөхий тусгайлсан нэгж байхгүй бөгөөд тухайн газар, хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчид үндсэн ажил үүргийнхээ хамт хэрэгжүүлэн ажиллаж байгаад дүгнэлт хийж нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэст гэрч, хохирогчийг хамгаалах

хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулах, удирдахад чиглэсэн 5 хөртөлх алба хаагчийн орон тоотой бие даасан нэгжийг Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст харьяалуулан байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах шаардлагатай юм.

Гэмт хэргийн статистик мэдээллийн чиглэлээр. Цагдаагийн байгууллагын Гэрч, хохирогчийг хамгаалах бүртгэлийн санд бүртгэгдсэн хамгаалалтын тоон мэдээг Гэмт хэргийн цагаан номд оруулж бүртгэгдсэн тоон мэдээ, цаашид хийж хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаар дүн шинжилгээ хийх. Ингэснээр гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд чухал үр дүн авчирч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ оновчтой, үр дүнтэй зохион байгуулагддана.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын ндсэн хууль.УБ.1992.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. УБ. 2014.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. УБ. 2018.

Т.Оюунчимэг. Гэрч. УБ. 2013.

Д.Энх-Амгалан. Гэрч, хохирогчийг хамгаалах асуудал. УБ. 2013.

П.Батбаатар. Гэрч хохирогчийн аюулгүй байдлын онол практикийн асуудал. 2021.

ЦЕГ-н Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн тоон мэдээ. УБ. 2020.

<https://www.legalinfo.mn/annex/details/6569?lawid=10750>

<https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5726.pdf> /Турк улсын хууль /

[http://base.garant.ru/12136633/Оросын холбооны улсын хууль/](http://base.garant.ru/12136633/Оросын_холбооны_улсын_хууль/)